



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/303

Номгон

Г Малын халдварт, гоц халдварт өвчнөөс Т
урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2020 онд
зарцуулсан хөрөнгөд хяналт шалгалт хийх тухай

Аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/443 дугаар захирамжаар баталсан “Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний хэрэгжилтийг хянах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “г”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх талаар дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулсугай.

2.Зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Л.Жаргалцэцэг - Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт, шалгалтын улсын Байцаагч

М. Гансум – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

П.Отгонбаяр – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн


Т.Саранчимэг – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

3.Хяналт, шалгалтын үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 18-ны дотор тооцож, дүгнэлт гарган, материалыг нотлох баримтын шаардлага хангуулан холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.

621010775

2.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН